

СОЁМБОМЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН 2021.07.06 №89 (89)

ХОЛЫН ЗАЙД ГҮЙЖ ЯВАА АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦАД БХЯ, ЗХЖШ-ЫН УДИРДЛАГА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



БХЯ, ЗХЖШ-аас Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамцад хүндэтгэл үзүүлэх ёслолыг өчигдөр ЗХЖШ-ын жагсаалын талбайд зохион байгууллаа. Монгол хүмүүн, монгол цэргийн эр зориг, тэсвэр хатуужлыг илтгэн харуулж, Ховд-Улаанбаатар-Чойбалсан хотын чиглэлд 2100 гаруй километр замыг гүйлтээр туулж яваа эрхэм ахлагчид хүндэтгэл үзүүлэх

ёслолд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг болон БХЯ, ЗХЖШ-ын удирдлага, бие бүрэлдэхүүний төлөөлөл оролцсон юм. ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзоригт Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамцад илтгэл өгсний

дараа ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг ёслолын ажиллагааг нээж үг хэлэв. Тэрээр хэлсэн үгэндээ, “Өнөөдөр Зэвсэгт хүчний өмнө дэвшүүлж байгаа бодлого, зорилтуудыг шийдвэрлэхэд хүний хүчин зүйлийн үүрэг, оролцоо улам бүр нэмэгдэж, цэргийн алба хаагчдаас мэргэжлийн өндөр ур чадвар, бие бялдар, сэтгэл зүйн өндөр бэлтгэлийг шаардах боллоо. Зэвсэгт хүчний хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг цэрэгжлийн спортын болон нийтийн биеийн тамир, спортын уралдаан, тэмцээнд хот, хөдөөгийн нэгтгэл, анги, салбаруудаас оролцогчдын тоо үлэмж нэмэгдэж, тэр ч чанараараа тэдний өрсөлдөх чадвар, тэмцээний явцад үзүүлж буй амжилт, эцсийн үр дүн нь улам бүр сайжирч байгааг онцлох учиртай” гэв. Үргэлжлүүлээд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай үг хэлж, БХЯ-ны шагнал болох 5 сая төгрөг, цэргийн дүрэмт хувцсыг гардуулан өгсөн бол Биеийн тамир, спортын улсын хорооны даргын тушаалаар Спортын мастер цол, ЗХЖШ-ын даргын тушаалаар “Зэвсэгт хүчний Биеийн тамир, спортын алдар” медалийг

хүртээснийг ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг гардууллаа. Түүнчлэн ЗХЖШ, Төрийн цэргийн командлал, нэгтгэл, ангиудын тэргүүн ахлагч нараас цуглуулсан хандивыг ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Б.Гантөмөр ахлах ахлагч Э.Даваажамцад гардуулж, амжилт ерөөсөн бол ЗХЖШ-ын Материал техникийн газрын Зэвсгийн хэлтсийн дарга, хурандаа П.Чинзориг “Бие амьтай яваарай, зэвсэг амьтай яваарай” гэдгийг тодотгоод гүйлтийн явцад ашиглаж, цаашид Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн цэргийн сургалт бэлтгэлд ашиглах сургалтын зориулалттай автомат бууг хүлээлгэн өгсөн бол 5.11 брэндийн компьютер “Бродер Мэрчантс” компанийн захирал Б.Тамир, Иргэний нисэхийн Ерөнхий газрын хамт олныг төлөөлж, Индра нар гарын бэлэг гардууллаа. Ташрамд, ЗХЖШ-аас мөрдэс нэгт дайчин нөхрийнхөө эр зориг, тэсвэр хатуужлыг өндрөөр үнэлэн сэтгэлийн дэм үзүүлж, хандив өргөхийг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, нийт бие бүрэлдэхүүнд уриалсан бөгөөд энэхүү хандивыг тун удахгүй ахлах ахлагч Э.Даваажамцад гардуулан өгөх болно.

“БИД БҮТЭЭВ” ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТОМАШИНУУДЫГ ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ

Батлан хамгаалах яамны 110, Зэвсэгт хүчний 100 жилийн ойг угтаж Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийнхны шинээр зохион бүтээсэн “Бид бүтэв” тусгай зориулалтын автомашинуудыг хүлээлгэн өгөх ёслолын ажиллагаа өчигдөр боллоо. Нээлтэд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, БХЯ-ны СБТГ-ын дарга, хурандаа С.Ганбямба, ЗХЖШ-ын орлогч дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, хурандаа Д.Номт, Хүний нөөцийн хэлтсийн дарга, хурандаа Н.Гантөмөр, Материал техникийн газрын штабын дарга, хурандаа З.Баянмөнх, Материал хангалтын хэлтсийн дарга, хурандаа С.Баяр-Очир, Зэвсэглэлийн хэлтсийн дарга, хурандаа П.Чинзориг, Эрүүл мэндийн хэлтсийн дарга, хурандаа Т.Сүхбаатар болон 011 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн тэдний ар гэрийн төлөөлөл оролцлоо.

автомашин үйлдвэрлээд байна. Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн захирагч, хурандаа М.Батдорж хэлэхдээ, “Энэхүү ажлыг хийх хугацаанд бид маш ихийг сурч, мэдэж, мэргэшлийн хувьд асар их дадлага туршлагыг хуримтлуулж, ангийн түүхэн хөгжлийн томоохон суурийг тавиад байна. Учирч байсан хүндрэлүүдээс гадна коронавируст цар тахал өвчний томоохон шалгууруудыг бид бүхэн даван туулсан. Бидэнд ухрах, алгуурлах цаг байгаагүйг та бүхэн бүгд мэдэж байгаа. Ангийн бие бүрэлдэхүүн өгсөн үүрэг даалгаврыг амжилттай гүйцэтгээд өнөөдөр БХЯ, ЗХЖШ-ын удирдлагуудын өмнө зогсож байгаа нь цэрэг хүний итгэл даах мөн чанар гэж ойлгож байна. Бид бүгдийн ажлыг бодлогын болон бүхий л шатанд дэмжсэн БХЯ, ЗХЖШ-ын удирдлага, хамт олонд талархлаа” гэв. Энэ үеэр дээрх автомашинуудыг оролцуулсан техникийн парадыг ангийн жагсаалын талбайд явуулав.



Зэвсэгт хүчний шинэ зууны түүхийг нээж байна гэж ойлгох хэрэгтэй. Хамтран ажилласан аж ахуйн нэгж болон зөвлөх инженер Ц.Баатар танд талархсанаа илэрхийлье. Танай ангийн зохион бүтээсэн техник хэрэгсэл, автомашинууд Зэвсэгт хүчний цаашдын хөгжилд томоохон түлхэц үзүүлэх болно. Яггүй олон үйл явдлыг та бүгд туулж гарсан. Шахуу хуваарийн дагуу ажилласан. Ар гэрийн хувьд ч хүндрэлтэй асуудлууд байсан. Гэсэн хэдий ч ажралгүй давж өнөөдөр техникуудээ хүлээлгэн өгч байна. Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг байгуулахад та бүхний ар гэр өндөр хувь нэмэр оруулсан гэдгийг

хэлмээр байна. Бусдыгаа уриалж, Зэвсэгт хүчний шинэ зууны түүхийг бүтээлцэж, чадавхийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсан та бүхэнд талархаж байгааг минь хүлээн авна уу” гээд албанд нь амжилт, амьдралд нь аз жаргал, эрүүл энхийг хүсэв. Мөн тусгай зориулалтын автомашинуудыг зохион бүтээхэд зөвлөх инженерээр ажилласан Ц.Баатар “Залуус, ялангуяа Зэвсэгт хүчний алба хаагчидтайгаа хамтран ажиллахад маш их хурд, эрч хүчийг мэдэрлээ. Би 1963 оны цэрэг. Тэр цагт байлдааны тугийн өмнө цэрэг хүний ёсоор эх орондоо тангараг өргөж байсан.

ЛҮРГЭЛЖЛЭЛ НЬ АРЫН НҮҮРТ!

ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
өдөр	шөнө
☀️ 24	🌙 10
ӨМӨНД СУДАН	
өдөр	шөнө
☀️ 33	🌙 22

ВАЛЮТЫН ХАНШ		
Валют	Авах	Зарах
USD 🇺🇸	2.851.00	2.853.00
EUR 🇪🇺	3.390.00	3.400.00
CNY 🇨🇳	441.00	442.00
RUB 🇷🇺	38.40	40.10
JPY 🇯🇵	25.36	25.84
KRW 🇰🇷	2.43	2.57

ЗУРХАЙ
АРГЫН ТООЛЛЫН:
2021.07.06
МЯГМАР ГАРАГ

ЗУНЫ ДУНД ХӨХ МОРЬ САРЫН НЭГ ЦАГАЧИН ХӨХӨГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

НАРАН УРГАХ ШИНГЭХ:
05.01-20.53

ҮС ЗАСУУЛБАЛ:
Өлзийтэй сайн

БАРИЛДЛАГА:
Арвидач

ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Сэрэхүй

Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гэрөө хийх, мал, адгуус муулах, хараал, жатхыг буцаах, амилуулах, өглөгийн түлэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн. Золиг гаргах, бомбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 126.811	ЭДГЭРСЭН 87.145	НАС БАРСАН 629/12
ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 342	ЭДГЭРСЭН 3147
НИЙТ БАТЛАГДСАН 3550(59)		

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохiolдол
Нийт: 183,788,043

Эдгэрсэн
Нийт:

Нас барсан
Нийт: 3,977,121

119 ТУСГАЙ ДУГААРТ ИРСЭН ИРГЭДИЙН АСУУЛТ БА ХАРИУЛТ

Ямар төлөвлөлтөд 14 өдөр гурван тусваралдах вэ?

(Ковид-19) элдэв бэлтгэлгүйгээр төлөвлөлийн өргөн хамтлага, хэдхэн минутад бүтэж, өрнөх нутагтай хамт хамарч байгаа бөгөөд 14 өдөр гурван тусваралдах болно.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АЛБА ХААГЧИД ТҮЙМРИЙН ХАЛЗ ЗУРВАСЫГ СЭРГЭЭЖ БАЙНА



Монгол орны түймрийн эрсдэлтэй бүс нутгийг 4 зэрэгт хуваан авч үздэг бөгөөд нийслэлийн ногоон бүсийн ойн сан бүхий газар нь түймрийн эрсдэлийн зэргээр 2 дугаар бүс буюу “Аюулын зэрэг өндөр” гэсэн ангилалд багтдаг. 1960-1999 оны хооронд нийслэлийн ногоон бүсэд ойн түймрээс хамгаалах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, 40 метрийн өргөн, 2 км хүртэлх урттай, нийт 10 зурвасыг байгуулж байсан бол сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд нийслэлийн хэмжээнд түймрийн халз зурвас сэргээх ажил хийгдээгүй юм. Нийслэлийн нутаг дэвсгэрт түймрийн халз зурвас байгуулах ажлыг 2017, 2018 онуудад хийлгэхээр нийслэлийн төсөвт тодорхой зардлыг тусгуулан нээлттэй сонгон шалгаруулалт явуулж байсан боловч төсөвт өртөг бага гэх шалтгаанаар тус ажлыг гүйцэтгэх хүсэлтэй нэг ч аж ахуйн нэгж, байгууллага шалгаруулалтад оролцоогүй

аж. Харин тус ажлыг Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчийн оролцоотойгоор өнгөрсөн оноос хийж эхэлжээ. Тухайлбал БОАЖЯ, Ойн судалгаа хөгжлийн төв УТӨҮГ-ийн дүгнэлт, нийслэлийн Онцгой байдлын газрын саналд үндэслэн түймэрт өртөх эрсдэлийн зэрэг болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан эхний ээлжид Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр Бага баянгаас Халзангийн ам руу чиглэсэн зурвас, мөн хорооны Шарга морьтын эхнээс зүүн хойш чиглэсэн нийт 2 км урттай 2 байршилд түймрийн халз зурвас шинэчлэн сэргээсэн юм. Энэ жилийн хувьд Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр Ар гүнтийн амны ойн санд 1,8 км урт, 40 метрийн өргөн газрын түймрийн халз зурвасыг шинэчлэн сэргээж байна. Тус ажлыг Зэвсэгт хүчний 310, 014

дүгээр ангийн 60 орчим алба хаагч 7 нэгж техниктэйгээр өнгөрсөн сарын 28-наас энэ сарын 10-ны өдрүүдэд хийж гүйцэтгэх бөгөөд өчигдрийн байдлаар тус ажил 60-70 хувьтай явагдаж байна. Мөн тус газраас гарсан зулган модны үндсийг нь гэмтээлгүй мод үржүүлгийн газарт хүлээлгэн өгч байгаа бөгөөд түүгээр нийслэл орчмын ойг нөхөн төлжүүлэх, ойжуулах ажилд нэмэр болох аж. Түүнчлэн түймрийн халз зурвас байгуулах, шинэчлэн сэргээх ажлыг хэрэгжүүлснээр ой хээрийн түймэр гарах, тархах аюулыг багасгах, түймрийн эрчмийг сааруулах, түймрийн тархалтын хурдыг бууруулах, түймэр зогсоох төдийгүй ногоон бүсэд амьдарч буй иргэд, айл өрхийн эд хөрөнгө, амь нас эрсдэлд орох аюулаас хамгаалах, урьдчилан сэргийлэх зэрэг олон төрлийн ач холбогдолтой юм.

ӨМНӨД СОЛОНГОСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ АМЕРИКИЙН “TIME” СЭТГҮҮЛД ЯРИЛЦЛАГА ӨГЛӨӨ

Доктор /Ph.D/, хурандаа Р.ЭНХБОЛД

Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Моон Жае-ин америкийн “TIME” сэтгүүлд ярилцлага өгч, солонгосын хойгт тулгараад буй аюулгүй байдлын талаар ярилцав. Ерөнхийлөгч Моон хэлэхдээ, “Хойд солонгосчууд маш их өөрчлөгдөж байгааг би харж байна, тэд хөгжихийн тулд бүхнийг хийж байна. Надад ерөнхийлөгчөөр ажиллах бага хугацаа үлдсэн гэдгийг мэднэ. Өмнөд, Хойд хоёр солонгосын хооронд тогтоод буй энх тайван байдал нь маш хэврэг бөгөөд хэзээ ч эвдэрч болзошгүй байдалд байгаа. Иймд хоёр солонгос нэгдэх, солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс нутаг болгохын тулд бүхийг хийх ёстой” гэв.



оны 3 дугаар сард дуусах ерөнхийлөгч Моон нь мухардмал байдалд ороод байсан АНУ, Өмнөд болон Хойд Солонгосын 3 талт уулзалтыг 2018 онд сэргээж, хоёр солонгосын

харилцааг зөөлрүүлэхэд хүчин чармайлт гаргаж, тодорхой амжилт үзүүлсэн хүн билээ.

/Эх сурвалж: time.com/

/ТУРҮҮЧ НЬ 1 НҮҮРТ/

“БИД БҮТЭЭВ” ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТОМАШИНУУДЫГ ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ



Үүрэг даалгавраа гүйцэтгээд, хугацаа дуусгавар боллоо гэж бодож байтал үгүй юм байж. Нэг ёсондоо эх орондоо үргэлжлүүлэн зүтгэсээр л байна. Үнэнийг хэлэхэд өнөөдөр их огшлоо. Үгээр илэрхийлэх ч юм биш. Олон шөнийн нойроо хасаж, хамт зүтгэсэн энэ сайхан

залуусаас нэг зүйлийг олж харлаа. Залуус элгэддэггүй, хурцлагддаг юм байна. Үүгээр биш бол өөр юугаар бахархах юм. Миний хувьд дээхэн үед МСҮТ-д багшилж байлаа. Тэгэхдээ бас нэг дугуйлан маягийн юм ажиллуулаад уралдааны загварын автомашин хийж байсан

бяцхан түүхтэй. Зэвсэгт хүчинд ашиглах тусгай зориулалтын автомашины зохион бүтээнэ гэдэг хүнд, амаргүй зүйл байна. Би цэргийн хүн биш учраас тэр жаргал, зовлонг нь сайн мэдэхгүй юм. Мэддэг, мэргэжлийн заслуустай нь хамтраад ажиллахад сайхан байлаа” гэсэн юм.



МӨНГӨН ХОНХНЫ БАЯР ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ...

ОУЛГҮЙ БАЙДЛЫН ДЭЭД СУРГУУЛ “ЭРДМИЙН БАЯР-2021”



Өчигдөр Монгол Улсын цэрэг, аюулгүй байдал, батлан хамгаалахын болон төр, хувийн хэвшлийн бүхий л салбарын өндөр мэдлэг, чадвар, ёс зүй, хүмүүжил төлөвшлөөр тэргүүлэгч, шилдэг хүний нөөцийг сурган бэлтгэдэг ҮБХИС-ийн 91, АБДС-ийн 17 дахь удаагийн төгсөлтийн мөнгөн хонхны баярын хүндэтгэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр 2 дахь жилдээ зохион байгууллаа. Ёслолын ажиллагаанд ҮБХИС-ийн Сургалт, цэргийн алба хариуцсан тэргүүн дэд захирал, хурандаа Ө.Эрдэнэ-Очир, Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэл хариуцсан дэд захирал, доктор, профессор, хурандаа Б.Өлзийхуяг, Сургалтын хэлтсийн дарга, доктор, дэд хурандаа Б.Мандахбаяр,

Аюулгүй байдлын дээд сургуулийн захирал, доктор, хурандаа Э.Нацагдорж, Эрдэм шинжилгээ сургалтын албаны дарга, доктор, профессор, Ч.Отгонбаяр болон АБДС-ийн тэнхимийн дарга нар, төгсөгчдийн төлөөлөл оролцлоо. Оюутан суралцагчдын хувьд сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын хөгжилд бодитой хувь нэмэр, амжилт бүтээлээр манлайлан жил байв. Энэхүү 2020-2021 оны хичээлийн жилд АБДС-ийн нийт 412 төгсөгчөөс 12 төгсөгч онцгойлох дипломын болзол хангасан нь оюутан суралцагчдын эзэмшсэн эрдэм мэдлэг, ур чадварын нэгээхэн жишээ юм. Үүний дотор ҮБХИС-ийн бусад их дээд, сургуулиудтай хамтран ажиллах, хамтынажиллагааны

цар хүрээ өргөжиж, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд ҮБХИС болон СЭЗИС, ХААИС-ийн хамтарсан хөтөлбөрөөр нийт 7 төгсөгч төгсөж байгаагаараа онцлог юм. Энэ удаагийн төгсөлтийн шилдгийн шилдэг төгсөгчдийн төлөөлөл болох Электроникийн тэнхимийн Цэргийн холбооны инженер хөтөлбөрөөр төгсөгч У.Ансалмаа, Электроникийн тэнхимийн Радио техникийн команд хөтөлбөрөөр төгсөгч О.Энхцэцэг, ЭЗМТ-ийн Эдийн засаг хөтөлбөрөөр төгсөгч М.Саранчулуун, Төрийн удирдлага хөтөлбөрөөр төгсөгч Б.Буяннэмэх, Менежмент хөтөлбөрөөр төгсөгч Д.Мягмарсүрэн нарт сургуулийн удирдлагууд энгэрийн тэмдэг, дипломыг гардуулав.